

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

MONGOLIA-JAPAN
Business Forum
20 May 2021



Хүн ам

3.2 САЯ



ЖИЛ ТУТАМ ДУНДЖААР



70,000

ХҮҮХЭД ШИНЭЭР ТӨРЖ БАЙНА.

ДНБ

13.32
ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

5.1 %

ӨСӨЛТ (2021 ОНЫ
УРЬДЧИЛСАН БАЙДЛААР)

Газар нутаг

1.5 САЯ КМ²

ГАЗАР НУТГИЙН
ХЭМЖЭЭГЭЭР

17



ДАЛАЙД
ГАРЦГҮЙ



Нийт ГШХО



29.6

(1990-2020)

ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

(123 ОРНООС ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ ХИЙГДСЭН)

ТОП ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

5 УЛСУУД:



КАНАД



БНХАУ



НИДЕРЛАНД



ЛЮКСЕМБУРГ



СИНГАПУР



НИЙТ
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН



70%

ОЛБОРЛОХ САЛБАРТ ХИЙГДСЭН.

Экспорт



7.6

ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

(142 УЛСТАЙ) (2020)

72.5%



БНХАУ



ЕВРОПЫН
ХОЛБООНЫ
УЛСУУД



СИНГАПУР



ИБУИНВУ



ОХУ

ТОП ЭКСПОРТ:



2.7

ХҮРЭН НҮҮРС
ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



2.1

ЗЭСИЙН ХҮДЭР
ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

ТОП ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД:



28%
ХҮРЭН НҮҮРС



23.6%
БОЛОВСРУУЛААГҮЙ ЭСВЭЛ
ХАГАС БОЛОВСРУУЛСАН
ХЭЛБЭРЭЭР АЛТ



23.5%
ЗЭСИЙН ХҮДЭР



8.4%
ТӨМРИЙН ХҮДЭР
БА БАЯЖМАЛ



НООЛУУР, НООС
(БОЛОВСРУУЛААГҮЙ)



ЭРДЭНИЙН
ЧУЛУУ



АЛТ

НӨӨЦ БОЛОМЖУУД:



ЭРЧИМ ХҮЧ (НАР, САЛХИНЫ
ЭРЧИМ ХҮЧНИЙ БОЛОМЖ НЬ
СУУРИЛАГДСАН ХҮЧИН
ЧАДАЛТАЙ БУЮУ 2600 ГИГАВАТТ
(GW) -ТАЙ ТЭНЦЭХҮЙЦ БУЮУ
5,457 ТЭРАВАТТ/ЦАГ ЦЭВЭР
ЦАХИЛГААН ҮЙЛДВЭРЛЭХ
БОЛОМЖТОЙ ГЭСЭН ТООЦОО
ГАРСАН)



ГАЗРЫН
ХОВОР
ЭЛЕМЕНТ
(31 САЯ ТОНН
ГАЗРЫН ХОВОР
НӨӨЦ)



НООЛУУР,
НООС,
НООЛУУРАН
БҮТЭЭГДЭХҮҮН
БОЛОВСРУУЛСАН



ОРГАНИК
АРЬС
АРЧИЛГАА



ОРГАНИК
ЗӨГИЙН
БАЛ,
ЧАЦАРГАНА



БОЛОВСРУУЛСАН
АРЬС, ШИР,
АРЬСАН ЭДЛЭЛ



МАХ: ҮХЭР,
ХОНИНЫ
МАХ, ХАЛАЛ
МАХ



СҮҮН
БҮТЭЭГДЭХҮҮН

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

MONGOLIA-JAPAN
Business Forum
20 May 2021

Импорт

5.3

ТЭРБУМ АМ.ДОЛЛАР
(72 УЛСТАЙ)



ТОП ИМПОРТЛОГЧ УЛСУУД:



ТОП ИМПОРТ:



БОЛОВСРУУЛСАН
НЕФТЬ

1.0

ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



МАШИНУУД БОЛОН
ЭД АНГИУД

815

САЯ АМ.ДОЛЛАР




БЭЛЭН БОЛОВСРУУЛСАН
ХҮНС



ХҮНСНИЙ НОГОО,
ЖИМС ЖИМСГЭНЭ



ХИМИЙН
БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



ГАН

Ковид19 вакцинжуулалт



2021 ОНЫ 5-Р САРЫН 1
БАЙДЛААР

МОНГОЛ УЛС ӨДӨРТ ДУНДЖААР

70,000



ХАМГИЙН ХУРДАН ДАРХЛААЖУУЛАЛТ
ХИЙЖ БАЙГАА ОРНООР ЖАГСЖЭЭ.
(РОЙТЕРС).

Соёл

МОНГОЛЫН СОЁЛ
БОЛ БӨӨ МӨРГӨЛ,
БУДДЫН ШАШНЫ
ИТГЭЛ ҮНЭМШИЛ
ШИНГЭСЭН
НҮҮДЭЛЧДИЙН
ҮНЭТ ЗҮЙЛ, ӨВ
УЛАМЖЛАЛААР
БАЯЛАГ БИЛЭЭ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



68.3% 53.4%



ХҮН АМЫН ТАЛ ХУВИЙГ
27-ООС ДООШ НАСНЫХАН

98%

БИЧИГ ҮСЭГ ТАЙЛАГДСАН

68.6%

ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ

ЖИЛД ДУНДЖААР
8.06%
ӨСЧ БАЙНА.

Цаг агаар

ДАЛАЙ ТЭНГИСЭЭС
АЛСЛАГДСАН, ӨНДӨРЛӨГ
ГАЗАРТ БАЙРЛАДАГ ТУЛ ЭХ
ГАЗРЫН ЭРС ТЭС УУР
АМЬСГАЛТАЙ -30 ХЭМ
ХҮРДЭГ МАШ ХҮЙТЭН ӨВӨЛ,
БОГИНО, ГЭХДЭЭ ДУЛААН ЗУН
БОЛДОГ, ЯЛАНГУЯА ГОВЬ
ЦӨЛД.



Монголд амьдрахуй



УЛААНБААТАР ХОТ

1.5 САЯ



100

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
ЭЛЧИН САЙДЫН ЯАМ, ҮНДЭСТЭН
ДАМНАСАН КОМПАНИУД БАЙДАГ



21 АЙМАГ
333 СУМ



ГЭМТ ХЭРЭГ
ХАМГИЙН БАГА ГАРДАГ
УЛСУУДЫН НЭГ ЮМ.

УЛААНБААТАР ХОТ НЬ БЭЭЖИН, СӨҮЛ, ТОКИО, ХОНКОНГ ЗЭРЭГ ДЭЛХИЙН
ТОМООХОН ХОТУУДААС 1.5-4 ЦАГИЙН ЗАЙТАЙ.

MON ENG

АЛБАН ЁСНЫ ХЭЛ НЬ
МОНГОЛ ХЭЛ БОЛОВЧ,
АНГЛИ ХЭЛИЙГ ҮГ
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ НЭГ
ХЭЛБЭР БОЛГОЖ
ТОДОРХОЙ ХЭМЖЭЭГЭЭР
АШИГЛАЖ БОЛНО.

Хоол хүнс



МОНГОЛ ХООЛ НЬ ГОЛДУУ СҮҮН
БҮТЭЭГДЭХҮҮН, МАХ, АМЬТНЫ
ГАРАЛТАЙ ӨӨХ ТОСНООС
БҮРДДЭГ. МОНГОЛ ОРНЫ ЭХ
ГАЗРЫН ЭРС ТЭС УУР АМЬСГАЛ
НЬ УЛАМЖЛАЛТ ХООЛ
ХҮНСЭНД ШИНГЭСЭН БАЙДАГ.
ХҮНСНИЙ НОГОО, ХАЛУУН
НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ
ХЯЗГААРЛАГДМАЛ БОЛОВЧ ТОМ
ХОТУУДАД ХЭРЭГЛЭХ НЬ ЭЛБЭГ.



Засаглал

МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨР НЬ ХАГАС
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН, ОЛОН НАМЫН ТӨЛӨӨЛЛИЙН
АРДЧИЛСАН ЗАРЧМААР ЯВАГДДАГ ГҮЙЦЭТГЭХ ЭРХ
МЭДЛИЙГ ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ЕРӨНХИЙ САЙД
ЭРХЭЛДЭГ. ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДЛИЙГ
ПАРЛАМЕНТ ЗАСАГЛАЖ, ШҮҮХ ЗАСАГЛАЛ НЬ
ГҮЙЦЭТГЭХ БОЛОН ХУУЛЬ ТОГТООХ
БАЙГУУЛЛАГААС ХАРААТ БУС БАЙДАГ.



МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

MONGOLIA-JAPAN Business Forum

20 May 2021

Олон улсын байгууллагуудын үзүүлэлт (2020)



МОНГОЛД БИЗНЕС ЭРХЛЭХҮЙ -

АЗИ НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ДУНД 10РТ:




**БАРИЛГЫН
ЗӨВШӨӨРӨЛ
АВАХ 6РТ**



**ХӨРӨНГӨ
БҮРТГҮҮЛЭХ
6РТ**



**ЗЭЭЛ АВАХ
4РТ**



**ХӨРӨНГӨ
ОРУУЛАГЧИЙН
ХАМГААЛАЛ 6РТ**



**ТАТВАР ТӨЛӨЛТ
7РТ**

**МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ
ЗЭРЭГЛЭЛ (MOODY'S)**

B3

ТОГТВОРТОЙ

ХАМГИЙН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙН
ТАТВАРААС

САН

Олон улсын зах зээлд нэвтрэх боломжууд, давуу талууд

**ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР (JMEPA)**

- Монголын талаас 5,700
- Японы талаас 9,300

(төрлийн бараа бүтээгдэхүүнийг харилцан импортын гаалийн татвараас шууд болон үе шаттайгаар чөлөөлөх)

**ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН
ЕРӨНХИЙ СИСТЕМ GSP+**

7200 бараа бүтээгдэхүүнийг ЕХ-ны улсуудад гаалийн тарифын хөнгөлөлт

**АНУ-ЫН ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ
СИСТЕМ GSP +**

АНУ-ын зах зээлд 3500 гаруй бүтээгдэхүүнд гаалийн татваргүй нэвтрэх нөхцөл

**АЗИ НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭЭР (ЭНЭТХЭГ, ӨМНӨД
СОЛОНГОС, ШРИ ЛАНКА, ЛАОС,
БАНГЛАДЕШ, БНХАУ)**

Гишүүн улсын зах зээлд 10,667 төрлийн бараа бүтээгдэхүүний тариф бууруулах

Монгол Улсын хөрөнгө оруулалтын боломжууд

ТЭРГҮҮЛЭХ

САЛБАРУУД ОЛОН УЛС ДАХ БАЙР СУУРЬ

НӨӨЦ

Уул уурхай




Монгол Улс 1170 орчим мэдэгдэж буй орд, 80 гаруй төрлийн ашигт малтмалын 10000 гаруй илрэл бүхий дэлхийн нөөцөөрөө дэлхийн 7-р байранд жагсаж байна.

Салбарын боломжууд:

- Хайгуулын тусгай зөвшөөрөл
- Шинэ боломжуудад хөрөнгө оруулалт хийх - зэс катод зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг
- Газрын ховор элементийг хайх, олборлох


Уул уурхай, хүнд үйлдвэрлэлээрээ дэлхийд:



хайлуур
жоншны
үйлдвэрлэлээр
3-рт,



коксжих
нүүрсний
олборлолтоор
7-рт,



молибден ба
вольфрам
(W-Content) -аар
10-рт



зэсийн
үйлдвэрлэлээр
16-рт

Батлагдсан нөөц

Дэлхийд эзлэх байр суурь

Ашигт малтмал

Зэс	57 сая тонн	12рт
Нүүрс	37.2 тэрбум тонн	23рт
Төмрийн хүдэр	1.2 тэрбум тонн	19рт
Алт	2,500 тонн	
Цайр	1.7 сая тонн	
Жонш	48.3 сая тонн	4рт
Уран	197.0 мян тонн	
Газрын тос	332.6 сая тонн	76 рт

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

MONGOLIA-JAPAN
Business Forum

20 May 2021

Монгол Улсын хөрөнгө оруулалтын боломжууд

ТЭРГҮҮЛЭХ

Хөдөө аж ахуй



- Ноолуурын нөөцөөрөө **2-рт**
- Ноосны экспортоор Азидаа **4-рт**
- Адууны махны үйлдвэрлэлээр **2-рт**
- Хонь, ямааны мах үйлдвэрлэлээр Азидаа **4-рт**

Салбарын боломжууд:

- Мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх
- Органик бүтээгдэхүүн: чацаргана ба зөгийн бал
- Мах экспортлох
- Дотоодын хэрэглээний хүнсний ногоо тариалалт

НӨӨЦ



67 сая

толгой малтай



1.3 сая га

тариалан тарих боломжит талбайтай.



31 хувь

ДНБ-ий 31 хувийг ХАА, хөнгөн үйлдвэрийн салбар бүрдүүлдэг.

Сэргээгдэх эрчим хүч



Азийг эрчим хүчээр хангах боломжтой нар, салхины шавхагдашгүй нөөцтэй.

Монгол Улс нь дэлхийн сэргээгдэх эрчим хүчний нөөцийн гуравны нэгийг үүсгэх боломжтой улсын хувьд, Азийн эрчим хүчний супер сүлжээ болох боломжтой.

Монгол Улсад 2,600 гегаватт (гВт) нар, салхины эрчим хүчний эх үүсвэрийг суурилуулж ашиглах боломжтой. Энэ нь жилд 5,457 тераватт (тВт)-цаг байгальд ээлтэй цэвэр эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал гэсэн үг юм. Энэхүү нөөцөөр эрчим хүчний дотоодын хэрэглээг (2018 оны байдлаар 1.2 гВт орчим) бүрэн хангаад зогсохгүй эрчим хүч дамжуулах дэд бүтцийг оновчтой шийдсэн тохиолдолд Зүүн хойд Азийн бүс нутгийн эрчим хүчний эрэлтийг хангах боломжтой юм. Засгийн газар Төрөөс эрчим хүчний талаар 2015-2030 онд баримтлах бодлогын хүрээнд эрчим хүчний системийн нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг **2023 онд 20%-д, 2030 онд 30%-д** тус тус хүргэж нэмэгдүүлэх зорилт тавьсан байна.



Цаашдын боломж:
Азийн супер сүлжээ

Мэдээллийн технологийн салбар Fintech & banking



Монгол Улс технологийн компаниудад ашиглагдаагүй асар том боломжийг нээж өгч байна. Энд боловсролтой, авъяаслаг мэдээллийн технологийн ажилчдын асар их хөдөлмөрийн нөөц байдаг бөгөөд цалин хөлс нь бусад хөгжингүй орнуудтай өрсөлдөх чадвартай байдаг.

- Интернет хэрэглэгч **2.6 сая**

- Ухаалаг утас хэрэглэгч **4.4 сая, 64%** нь (3G-5G) хэрэглэгч

- Хүн амын **93%** нь санхүүгийн байгууллагад данстай

- Хүн амын **22%** гар утсаараа дансаа удирдаж, төлбөр тооцоо хийдэг (Start-up) Гарааны бизнесийн амжилтууд: Монгол дахь технологийн авъяас чадвар, өндөр чанартай гарааны бизнесүүдийг хөгжүүлэх нь хоёулаа мэдэгдэхүйц хурдацтай өсөн нэмэгдэж, нилээд олон гарааны бизнесүүд дэлхийн хэмжээнд өрсөлдөж байна. Финтекийн зарим компаниуд Азид бизнесээ экспортолж эхэлсэн.



Тээвэр логистик



Монгол бол Ази, Европийг холбосон тээвэр, логистикийн **зангилаа худалдааны найдвартай коридор** юм.

45 хоног зарцуулах далайн замтай харьцуулахад хуурай газрын замаар **11** хоног зарцуулдаг.

2014 онд ОХУ, БНХАУ-ын хооронд төмөр замаар тээвэрлэсэн нийт бараа эргэлтийн **89%** нь Забайкальск-Манжуур боомтоор, **7%** нь Монголоор, **4%** нь Казахстангаар дамжин өнгөрчээ.

Цаашдын боломжууд:

Зам ба бүс


Орос, Хятадыг холбосон хийн хоолой

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

MONGOLIA-JAPAN Business Forum

20 May 2021

Хөрөнгө оруулагчийн хувьд Монгол Улс Таньд:



ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛЖ

- Гадаадын хөрөнгө оруулагчтай эрх тэгш хандах бодлого
- Таны бизнес цэцэглэн хөгжихөд зориулсан тогтворжуулалтын багц
- Эдийн засгийн чөлөөт бүсэд Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эхний 5 жил
- 60 + 40 хүртэлх жилийн хугацаатай газар ашиглах эрх
- Инновацлаг, бүтээлч гарааны бизнесүүдэд илүү боломжийг олгож ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шинэ бизнесээ турших sandbox аргыг санал болгож байна.



ТАНД ЗОРИУЛСАН ДЭМЖЛЭГ, СУРТАЛЧИЛГАА

- Хөрөнгө оруулагчдад зориулсан нэгдсэн мэдээллийн хуудас www.investmongolia.gov.mn-д зочлох;
- Хөрөнгө оруулагчдад зориулан англи, монгол хэл дээр сар тутам эрхлэн гаргадаг "Invest in Mongolia" цахим сэтгүүл;
- Хөрөнгө оруулалт хийх бизнесийн төслүүдийг Pitchbook 2021-ээс;
- Үндэсний бизнесүүдийг олон улсын зах зээлд сурталчлах, хөрөнгө оруулагчдад танилцуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой "Төсөл чадавхижуулах хөтөлбөр";
- Удахгүй болох "Invest in Mongolia" Токио 2021, Сөүл 2021 арга хэмжээнүүдэд бүртгүүлэх
- Дараах манай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зочилж, шинэлэг мэдээлэл авч байгаарай-<https://www.facebook.com/nda-govMN> <https://twitter.com/ndagovMN>

ЦАХИМЖСАН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

- Гадаадын хөрөнгө оруулагчтай эрх тэгш хандах бодлого
- Таны бизнес цэцэглэн хөгжихөд зориулсан тогтворжуулалтын багц
- Эдийн засгийн чөлөөт бүсэд Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эхний 5 жил
- 60 + 40 хүртэлх жилийн хугацаатай газар ашиглах эрх
- Инновацлаг, бүтээлч гарааны бизнесүүдэд илүү боломжийг олгож ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шинэ бизнесээ турших sandbox аргыг санал болгож байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХАМГААЛЛЫН МЕХАНИЗМ:



- Хөрөнгө оруулалттай холбоотой өргөдөл гомдлыг www.ipc.gov.mn эсвэл Ерөнхий сайдын удирдсан Хөрөнгө оруулалтын зөвлөлөөр дамжуулан шийдвэрлэдэг
- Шүүх үйлчилгээ нь олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжийн дагуу үүссэн маргааныг шийдвэрлэх боломжтой;
- Танд бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийхэд туслах чадварлаг, мэргэшсэн мэргэжилтнүүдтэй /home doctors/ ажлын алба нь Үндэсний хөгжлийн газарт ажилладаг.
- Үндэсний хөгжлийн газрын ажилтнууд Монгол Улсад таны өмнөөс бусад талуудтай гэрээ байгуулж таны бизнес, хөрөнгө оруулалтын хамгаалалтыг баталгаажуулна
- Монголд бусад талуудтай хамтран ажиллахад тань Таны бизнес, хөрөнгө оруулалтыг хамгаалахад дэмжлэг үзүүлнэ.